

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.БАЯНМӨНХ



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН СПОРТ  
ЗААЛАНД МӨРДӨХ ЖУРАМ

2017-12-21

Улаанбаатар хот

Энэхүү журам нь спорт зааланд зохион байгуулагдах уралдаан тэмцээн, бэлтгэл, чөлөөт тоглолтын үед сахилга, дэг журам, зохион байгуулалтыг хангахад чиглэгдэнэ.

1. Спорт зааланд батлагдсан хуваарийн дагуу тоглолт явагдана.
2. Заалны эд хөрөнгөнд эвдрэл гэмтэл учруулсан тохиолдолд шинээр худалдан авах буюу шинэчлэн засварлахад гарах зардалыг төлнө.
3. Тоглолтын талбайд зөвхөн биеийн тамирын хувцас, тоглолтын хувцас, кет, пүүзтэй гарна.
4. Тоглолтын талбайд өмсөх кет, пүүз нь хараас өөр өнгийн ултай байна.
5. Станцын захиргаанаас томилогдсон ажилтнаас заал, бөмбөг, техник хэрэгсэлийг хүлээн авч тоглолт дууссаны дараа цэвэрлэж хүлээлгэн өгнө. Цэвэрлэгээ хийгээгүй тохиолдолд тоглолтын хуваарийг нэг 7 хоног ухрааж тоглуулна. Шал, хананд хар зураас гаргасан, бохирдуулсан тоглогч нар цэвэрлэж хэвийн болгож хүлээлгэн өгнө.

Спорт зааланд дараах зүйлийг хатуу хориглоно. Үүнд:

1. Зааланд согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэсэн үедээ орох,
2. Тамхи татах, ус ундааны сав, бохь, хог хаягдлыг зориулалтын саванд хийхгүй ил хаях,
3. Зааланд шүлс, цэр хаях,
4. Тоног төхөөрөмж, бөмбөг, спортын хэрэгсэлийг зориулалт бусаар ашиглах, хананы цаг, цонх, хана руу бөмбөг шидэх, өшиглөх,
5. Тоглолтын талбайд гадуур хувцас, гадуур өмссөн гуталтай орох, тоглолтын кет, пүүзтэй заалнаас гарах,
6. Спорт заал болон тоног хэрэгсэлийг зориулалт бусаар хэрэглэх.
7. Тоглолтын талбайд гадуур хувцастай орох,
8. Шал зурах, урах эд зүйлс зааланд оруулах, тайл айд гаргах,
9. Тоглолтын бөмбөг, бусад эд зүйлсийг зөвшөөрөлгүй заалнаас гаргах,
10. Зааланд хэрүүл, маргаан гаргах, зодолдохыг тус тус хатуу хориглоно.

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ХХК-ИЙН  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС